



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/41

Ховд


Э.Дөлбадралд төрийн алба хаасан хугацааны  
нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоол, “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн албанд 2015 оноос хойш тасралтгүй ажиллаж байгаа Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Э.Дөлбадралын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түшинг үндэслэн албан тушаалын цалинг ТЗ-10 зэрэглэлийн 4 шатлал 1035204 /нэг сая гучин таван мянга хоёр зуун дөрөв/ төгрөгөөр тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 5 хувиар, нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 30 хувиар тус тус тооцож олгосугай.

2. Шинэчлэн тогтоосон шатлал, нэмэгдлийн дагуу цалинг 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн сар бүр олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Ерөнхий нягтлан бодогч /Г.Эсбаатар/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02.0318  
IDZAh-A/41-Bo